

ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТИЙН ТҮҮВЭР СУДАЛГАА



2012 ОНЫ 3 САР

МӨНГӨНИЙ БОДЛОГО, СУДАЛГААНЫ ГАЗАР СУДАЛГААНЫ ХЭЛТЭС

Танилцсан:

Ерөнхийлөгч

Л.Пүрэвдорж

Хянасан:

МБСГ-ын захирал

Д.Болдбаатар

СХ-ийн захирал

Н.Амар

Боловруулсан:

СХ-ийн эдийн засагч

А.Ананд


ХЭРЭГЛЭГЧДИЙН ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТИЙН ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ДҮН

Түүвэр судалгаанд Улаанбаатар хотын 9 дүүргийн 135 хорооноос 1013 иргэдийг санамсаргүй түүврийн аргачлалаар сонгож хамрууллаа. Судалгааны үр дүнгээр иргэд инфляцийг 3 сарын дараа **16.7%**, хагас жилийн дараа **15.0%**, жилийн дараа **14.1%** болж, одоогийн инфляцийн түвшингээс өсхөөр хүлээж байна. Мөн үнийн өсөлтийг тодорхой тоон заагуудаас асуухад иргэд инфляцийг жилийн дараа дунджаар **9.6%** болно гэж үзжээ.

Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

- Судалгаанд оролцогчдын 58.6% нь эмэгтэй;
- Насны бүтцийг харвал 55.3% нь 25-44 насны;
- Боловсролын түвшингээр авч үзвэл 85.7% нь бүрэн дунд болон дээд боловсролтой;
- Ам бүлийн тоог харвал 80.7% нь 2-5 ам бүлтэй;
- Ажил эрхлэлтийн байдлыг авч үзвэл 52.8% нь хувийн салбарт ажилладаг, 14.4% нь төрийн албанд, 25.2% нь ажилгүй;
- Өрхийн орлогын зүгээс харвал 67.9% нь 200-600 мянган төгрөгийн орлоготой, 13.0% нь 200 мянгаас бага, 19.1% нь 600 мянган төгрөгөөс дээш орлоготой өрхүүд байлаа.¹


Зураг 1.1 Жилийн инфляцийн хүлээлтийн чиглэлийн индекс



Санамж: [-1;0[үнэ буурна, [0] үнэ өөрчлөгдөхгүй, [0;1] инфляци одоогийнхоос буурна, [1;2] инфляци одоогийнхтой адил түвшинд байна, [2;3] инфляци одоогийнхоос хурдан өснө.

Зураг 1.2 Ирэх 12 сарын хугацаанд үнийн түвшин хэрхэн өөрчлөгдөх вэ?

- 1. Үнэ өснө, гэхдээ илүү хурдацтай өснө
- 2. Үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац өөрчлөгдөхгүй
- 3. Үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац буурна
- 4. Үнэ өөрчлөгдөхгүй
- 5. Үнэ буурна
- 6. Мэдэхгүй



¹ Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 1 – ээс харна уу.


² Дэлгэрэнгүйг хавсралт 2-оос харна уу.

³ 2012 оны 2-р сард Улаанбаатар хотын инфляци 13.3% байна.


1. Хүлээлтийн ерөнхий хандлага

Чиглэлийн индекс² нь иргэдийн инфляцийн хүлээлтийн хандлагыг харуулах бөгөөд индексийн утга ихсэх нь хүлээлтийн түвшин ихсэж байгааг, эсрэгээрээ буурвал хүлээлт намжиж байгааг илтгэнэ. Зураг 1.1-ээс харахад иргэдийн хүлээлт 2011 оны 1, 6-р сарууд болон 2012 оны 1-р сард хамгийн өндөр түвшиндээ хүрч иргэдийн дунд “инфляци одоогийнхоос хурдан өснө” гэж үзэх хандлага давамгайлсан байна. Эдгээрээс бусад үеүүдэд болон сүүлийн судалгааны дүнгээр иргэд “инфляци одоогийн түвшиндээ байна” гэж үзэх хандлагатай болжээ. Энэ нь хүлээлт өмнөх судалгааны дүнгээс бага зэрэг буурсан мэт харагдаж байгаа хэдий ч одоогийн инфляцийн түвшин хоёр оронтой тоонд³ байгаа нь хүлээлт харьцангуй өндөр байгааг харуулж байна. Хүлээлтийн чанарын хариулт (Зураг 1.2) – аас харвал нийт иргэдийн 77.5% нь ирэх 12 сард үнийн түвшин ерөнхийдөө өснө гэж үзсэн бөгөөд үүнээс 32.4 нь *үнийн түвшин хурдацтайгаар өснө* гэж хариулжээ. Энэ нь өмнөх судалгааны дүнгээс 5.5 нэгжээр буурсан байна.


Зураг 2.1 Инфляци, дундаж инфляци



Зураг 2.2 Жилийн инфляцийн хүлээлт (объектив, субъектив)



Зураг 3.1 Хүлээлтийн түвшин, тоон хариулт /ирэх 12 сарын хугацаанд/



2. Инфляцийн хүлээлтийн тоон утга

Иргэдийн өгсөн чанарын хариултуудыг ашиглан Карлсон-Паркин⁴ нарын магадлалын аргаар⁵ хүлээгдэж буй инфляцийн түвшинг объектив болон субъектив хандлагаар тооцооллоо. Өнгөрсөн хугацааны дундаж инфляцийн түвшинг суурь болгон инфляцийн хүлээлтийг тооцоолохыг **субъектив хүлээлт** гэдэг бол одоогийн инфляцийн түвшинг суурь болгон тооцоолохыг **объектив хүлээлт** гэнэ.

Зураг 2.1-г дундаж инфляци болон инфляцийг харууллаа. Өнгөрсөн хугацааны дундаж инфляци нь одоогийн түвшингээс өндөр байвал өнгөрсөн үед инфляци өндөр байсныг илтгэх бөгөөд энэ нь иргэдэд мэдрэгдэж буй инфляци нь одоогийн инфляцийн түвшингээс өндөр байх магадлалыг нэмэгдүүлнэ. Харин эсрэгээрээ дундаж нь одоогийн инфляциас бага тохиолдолд иргэд инфляцийг одоогийн түвшнээс арай багаар мэдрэх магадлалтай.

Зураг 2.2-оос харахад объектив хүлээлт нь сүүлийн судалгааны дүнгээр **14.1%** буюу иргэд жилийн дараа инфляци одоогийн түвшнээсээ бага зэрэг өснө гэж үзсэн байна. Харин субъектив хүлээлтийг (Зураг 2.1) харвал тоон утгаараа объектив хүлээлтээсээ бага боловч суурь утгаасаа буюу дундаж инфляцийн түвшингээс бага зэрэг (0.6 нэгжээр) өсч **10.0%** болжээ.


3. Инфляцийн хүлээлтийн тоон хариулт

Иргэдийн 12 сарын дараах хүлээлтийн түвшинг тодорхой тоон завсраас асуух замаар тооцоолол хийлээ. Зураг 3.1-ээс харахад судалгаанд оролцсон иргэдийн 24% нь инфляцийг 12 сарын дараа 9-11%-д, 21% нь 7-9%-д, 15% нь 5-7%-д, 14% нь 11-13% байна гэж үзсэн бөгөөд иргэдийн тоон хариултуудын дундаж утга буюу иргэд 12 сарын дараа инфляцийг **9.6%** байна гэж хүлээж байна.

⁴ Carlson, John A. and Parkin, Michael /1975/: Inflation expectations. "Economica" 42, pp. 123-38.

⁵ Дэлгэрэнгүйг хавсралт 3-аас харна уу.


Зураг 4.1 Иргэдийн 12 сарын дараах хүлээлтийн харьцуулалт



4. Хүлээлтийн харьцуулалт

Иргэдийн улирлын хүлээлтийн тоон утгуудыг харьцуулан харвал хагас жилийн эцсээр субъектив хүлээлт нилээд өсч 24.0% хүрсэн бол объектив хүлээлтийн дүн 16.7% -тай байна. Харин 6 сарын дараа буюу 9-р сарын эцсээр субъектив хүлээлт буурсан ч мөн л өндөр хэвээр 17.4%, харин объектив хүлээлтийн дүн 15.0% байна. Жилийн хүлээлтийн түвшинг харвал объектив хүлээлт 14.1% байхад субъектив хүлээлтийн түвшин огцом буурч 6.5% болсон байна. Иргэдээс авсан тоон утгыг харвал жилийн дараа инфляци 9.6% болно гэж хариулжээ.


Зураг 5.1 Таны бодлоор ирэх 12 сарын хугацаанд банкны зээлийн хүү хэрхэн өөрчлөгдөх вэ?



5. Бусад асуултуудын дүн

Судалгаанд оролцогчдын **39.4% нь ирэх 12 сарын хугацаанд зээлийн хүү өснө** гэж үзсэн нь өмнөх судалгааны дүнгээс 5 нэгжээр буурсан хэдий ч бусад судалгаануудын дүнгүүдтэй харьцуулахад өндөр хэвээр байна. Харин зээлийн хүү хэвэндээ байна гэсэн хариулт бага зэрэг өсч, хүү буурна гэсэн хариулт өөрчлөлтгүй гарсан байна.

Зураг 5.1.а Зээлийн хүүний хүлээлтийн чиглэлийн индекс ба зээлийн хүү




Санамж: Чиглэлийн индекс нь [-1;1] завсарт утгаа авна. [0;-1] өснө, [0] хэвэндээ байна, [0;-1] буурна.


Иргэдийн зээлийн хүүний хүлээлтийн чиглэлийн индексийг харвал 2011 оны 1-р сараас 6-р саруудад явагдсан судалгаануудын дүнгээр зээлийн хүүг буурна, хэвэндээ байна гэж хүлээх хандлагатай байсан бол бусад үеүүдэд үргэлж өснө гэж үзсэн байна. 2012 оны 1-р сарын судалгааны дүнгээр индекс огцом өсөөд байсан бол энэ удаагийн судалгаагаар индексийн утга өмнөхөөс буурч гарсан байна. Өөрөөх хэлбэл хүүний хүлээлт бага зэрэг буурсан байна.

Банкуудын зээлийн жигнэсэн дундаж хүүний түвшинг харахад 10-11 оны эцэс хүртэл тогтмол буурч ирсэн боловч 11 оны эцсээс нилээд хэлбэлзэх болсон байна. Сүүлийн үед эдийн засагт халалтын шинж тэмдгүүд илэрч, инфляцийн дарамт нэмэгдэж буйтай холбоотойгоор Төв Банк бодлогын хүүгээ хэд хэдэн удаа өсгөснөөр арилжааны банкууд хүүгээ өсгөж, зээл олголтгоо хумих болсон.

Зураг 5.2 Таны бодлоор ирэх 12 сард төгрөгийн ханш хэрхэн өөрчлөгдөх вэ?




Зураг 5.2.а Төгрөгийн ханшийн чиглэлийн индекс ба төгрөгийн ханшийн жилийн өөрчлөлт



Санамж: Чиглэлийн индекс нь [-1;-1] завсарт утгаа авна. [0;-1] хани суларна, [0] хэвэндээ байна, [0;-1] чангарна.

Зураг 5.3 Таны бодлоор ирэх 12 сард хадгаламжинд мөнгө хийхэд тохиромжтой үе мөн үү?



Энэ нь иргэдийн хүүний талаарх хүлээлтийн хандлагыг өндөрт барьж буй нэг хүчин зүйл нь болж байна.

Судалгаанд оролцсон иргэдийн **40% гаруй нь ирэх нэг жилд төгрөгийн ханш чангарна** гэж үзсэн нь өмнөх судалгаануудтай харьцуулахад **хамгийн өндөр түвшиндээ** хүрлээ. Харин эсрэгээрээ төгрөгийн ханш суларна гэж үзсэн иргэдийн хувь өмнөхөөс огцом буурсан боловч бусад судалгааны дүнгүүдтэй харьцуулбал өндөр хэвээр байна.

Иргэдийн төгрөгийн ханшийн хүлээлтийн чиглэлийн индексийг харвал 2011 оны эхэнд хийсэн судалгаанууд болон энэ удаагийн судалгааны дүнгээр ханш чангарна гэсэн хүлээлттэй гарсан байна. Мөн төгрөгийн ам.доллартай харьцах албан ханшийн тоон мэдээнээс харвал 2011 оны эцэст нэрлэсэн ханш 11%-иар сулраад байсан бол 2012 оны 3-сарын байдлаар эргэн чангарах хандлагатай болж байна.


Судалгаанд оролцогчдын **34% нь ирэх 12 сарын хугацаанд хадгаламжинд мөнгөө байршуулахгүй** гэж үзэж байгаа нь өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад 6 нэгжээр буурсан байна. Харин мөнгөө байршуулах иргэдийн хувь 4 нэгжээр өсч 25%-д хүрчээ.

2012 оны 2-р байдлаар хадгаламжийн бодит хүү сөрөг⁶ түвшинд очсон бөгөөд төгрөгийн хадгаламж болон нийт хадгаламжийн өсөлтийн хурдац⁷ он гарснаас хойш буурах хандлага үргэлжилсээр байна.

⁶ 2012 оны 2 сарын байдлаар хадгаламжийн жигнэсэн дундаж хүүнээс Улаанбаатарын инфляцийн түвшинг хасаж тооцсон бодит хүү -2.5% байна.


⁷ 2012 оны 2-р сард нийт хадгаламжийн жилийн өсөлт оны эцэст 41.1% байснаас 26.7%, төгрөгийн хадгаламжийнх 45.5% байснаас 29.6% болж буурсан байна.

Зураг 5.4 Танай өрхийн санхүүгийн байдал ирэх 12 сарын хугацаанд хэрхэн өөрчлөгдөх вэ?



Ирэх 12 сарын хугацаанд иргэдийн **өрхийн санхүүгийн байдал сайжирна гэж судалгаанд оролцогчдын 40% гаруй нь үзсэн** нь өмнөх судалгааны дүнгээс 15 нэгжээр өссөн бөгөөд бусад судалгаануудтай харьцуулахад хамгийн өндөр түвшиндээ хүрчээ. Харин хэвэндээ байна, муудна гэсэн хариултуудын хувь өмнөх судалгаанаас 12.4 нэгжээр буурч 45.6%-д хүрсэн бөгөөд үүнээс муудна гэсэн хариултын хувь хэмжээ 4 нэгжээр буурч 10.5%-д хүрсэн байна.

Зураг 5.4.а Өрхийн санхүүгийн байдлын талаарх хүлээлтийн чиглэлийн индекс



Санамж: Чиглэлийн индекс нь [-1;-1] завсарт утгаа авна. [0;1] өрхийн санхүүгийн байдал сайжирна, [0] хэвэндээ байна, [0;-1] муудна.

2008 оны эцэст хийгдсэн судалгааны дүнгээр иргэдийн дийлэнх нь ирэх 12 сарын хугацаанд өрхийн санхүүгийн байдал нь муудна гэж үзэх хандлагатай байсан бол 2009 оны 9-р сараас хойш хийгдсэн судалгаануудаар ирэх 12 сард сайжирна гэсэн хандлага давамгайлах болсон байна. Чиглэлийн индекс 2012 оны 1-р сарын судалгааны дүнгээр өмнөхөөс буурч гарсан ч энэ удаагийн судалгаагаар огцом өсөлттэй гарлаа. Өөрөөр хэлбэл иргэдийн өрхийн санхүүгийн байдлын хүлээлт эрс нэмэгдсэн байна.


Өмнөх судалгаануудын дүнгээс харахад хүлээлт буурсан үеүүдэд инфляцийн түвшин үргэлж 2 оронтой тоонд орсон байхад, хүлээлт сайжирсан үед инфляци харьцангуй доогуур түвшинд байсан бол энэ удаагийн дүнгээр инфляци харьцангуй өндөр ч хүлээлт огцом өссөн байна.

Зураг 5.4.б Сайжрах бол шалтгаан нь юу вэ?



Өрхийн санхүүгийн байдал сайжирна гэж судалгаанд оролцсон иргэдийн 40% нь хариулсан бөгөөд **тэдгээрийн 54% нь ирэх 12 сард цалин болон бизнесийн орлого нэмэгдэнэ** гэж үзсэн байна. Мөн 22% нь үл хөдлөх хөрөнгийн үнэ өснө гэж хариулсан нь иргэдийн эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ өсч, түүнээсээ орлого олно гэж үзсэн байна. Үүнээс гадна иргэдийн 14% нь өрхийн гишүүн ажлын байртай болно гэжээ.

Зураг 5.4.в Муудах бол шалтгаан нь юу вэ?



Өрхийн санхүүгийн байдал муудна гэж иргэдийн 10.5% нь хариулсан бөгөөд тэдгээрийн 50% нь ирэх 12 сарын хугацаанд үнэ өссөнөөс шалтгаалан өрхийн санхүүгийн байдал муудна гэж үзжээ. Харин 21% нь цалин болон бизнесийн орлого буурна, 10% өрхийн гишүүн ажилгүй болно, мөн 10% нь татварын ачаалал ихэснэ гэж үзжээ.

ДҮГНЭЛТ

Өмнөх судалгааны дүнгээр инфляцийн хүлээлтийн ерөнхий хандлага буюу чиглэлийн индекс өсч “инфляци одоогийнхоос хурдан өснө” гэсэн мужид байсан бол энэ удаагийн судалгаагаар бага зэрэг буурч “инфляци одоогийн түвшиндээ байна” гэсэн мужид орсон байна. Энэ нь өмнөх судалгаанаас буурсан боловч инфляци хоёр оронтой тоонд байгаа өнөө үед хүлээлт өндөр байгааг харуулж байна. Инфляцийн хүлээлтийн объектив хандлагыг жишиг болгон мөрдөх нь тохиромжтой бөгөөд хүлээлт 1 улирлын дараа одоогийн түвшнээс өсч 16% орчимд, 6 сарын дараа 15% орчимд байхаар хүлээж байгаа бол жилийн дараа 14% орчимд байна гэж хүлээж байна.

Бусад асуултуудын дүнг өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад иргэдийн хүлээлт сайжрах эерэг дохионууд харагдаж байна. Тухайлбал өмнөх судалгаагаар зээлийн хүү өснө гэж иргэдийн дийлэнхи нь үзэж байсан бол энэ удаагийн судалгаагаар бага зэрэг буурч гарсан. Гэсэн ч энэ нь өндөр түвшинд хэвээр байна. Мөн төгрөгийн ханш ирэх 12 сард чангарна гэж үзсэн иргэдийн хувь өмнөх судалгаануудаас хамгийн өндөр түвшиндээ хүрсэн байна. Эндээс иргэдийн төгрөгт итгэх итгэл эргэн сайжирч байгаа нь ажиглагдаж байна. Түүнээс гадна ирэх жилд өрхийн санхүүгийн байдал сайжирна гэж үзсэн иргэдийн хувь мөн хамгийн өндөр түвшиндээ хүрсэн бөгөөд тэдгээрийн дийлэнхи нь цалин, бизнесийн орлого нь өснө, үл хөдлөх хөрөнгийн үнэ өснө, өрхийн гишүүд ажлын байртай болно гэсэн хүлээлттэй байна. Харин арван хүн тутмын нэг нь өрхийн санхүү муудна гэснээс ихэнхи нь үнэ өсч, цалин болон бизнесийн орлого муудна гэсэн байна.

Ирэх 12 сарын хугацаанд иргэдийн дийлэнх нь хадгаламжинд мөнгө хийхэд тохиромжгүй болон мэдэхгүй гэж үзсэн хэвээр байна. Эндээс эдийн засагт тодорхой бус байдал их байгаа мөн иргэд хуримтлал үүсгэх санхүүгийн боломж тааруу байна гэж дүгнэж болхоор байна.

**Хавсралт 1. Санал асуулгад оролцсон иргэдийн ерөнхий мэдээлэл
(хувиар)**

	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X
Санал асуулга явуулсан огноо	2008-12 сар	2009-09 сар	2010-01 сар	2010-07 сар	2011-01 сар	2011-03 сар	2011-06 сар	2011-09 сар	2012-1 сар	2012-3 сар
Нийт асуулгад оролцсон иргэдийн тоо	1046	1000	1015	1000	1006	1030	1058	1023	1036	1013
Хүйс	Эрэгтэй	43.2	36.8	39.4	37.3	37.2	34.3	37.5	36.4	41.4
	Эмэгтэй	55.0	63.2	60.6	62.7	62.8	65.7	62.5	63.7	58.6
	Нийт	98.2	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Нас	18-24	31.2	21.2	19.6	25.4	24.5	28.3	21.5	22.6	19.8
	25-34	22.7	26.8	28.0	30.9	33.2	28.6	32.1	27.7	29.1
	35-44	19.9	25.1	20.9	21.9	22.9	18.2	23.4	22.9	24.1
	45-54	16.0	17.0	18.2	14.1	12.9	14.1	13.3	15.7	15.3
	55-аас дээш	10.3	9.9	13.3	7.7	6.6	10.8	9.6	11.1	11.7
	Нийт	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Боловсрол	Дээд	50.7	49.6	60.3	52.4	49.8	47.7	46.6	42.6	45.1
	Бүрэн дунд	36.3	40.2	31.1	39.6	37.6	40.8	39.4	45.9	41.6
	Бүрэн бус дунд	9.6	8.3	8.0	7.6	10.4	10.0	12.6	10.5	11.8
	Бага	2.3	1.1	.5	.2	1.1	1.4	1.2	.7	1.2
	Боловсролгүй	1.1	.8	.1	.2	1.1	.2	.2	.3	.4
	Нийт	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Ам бүлийн тоо	1	4.4	2.3	3.0	3.7	4.9	5.7	6.7	4.1	3.5
	2-3	33.8	36.9	36.8	38.6	39.5	34.1	43.4	40.1	36.9
	4-5	45.3	46.7	43.0	43.6	41.8	46.6	41.7	41.7	45.1
	5-аас дээш	16.6	14.1	17.2	14.1	13.8	13.6	8.2	14.1	14.6
	Нийт	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Ажил эрхлэлт	Төрийн алба	15.8	16.2	13.2	14.7	12.7	14.5	16.8	17.7	17.5
	Хувиараа	26.9	26.2	27.2	27.1	30.6	28.3	32.2	27.7	23.7
	Хувийн байгууллага	19.2	22.8	25.5	34.2	31.4	21.5	27.4	20.2	23.5
	Төрийн бус байгууллага	5.5	4.6	6.3	4.0	5.1	6.2	4.5	5.1	4.2
	Гадаадын байгууллага	-	-	-	-	-	-	-	1.5	.5
	Цагийн ажил	5.1	2.4	1.6	2.8	2.4	3.0	3.0	3.8	3.4
	Ажилгүй	-	24.3	24.8	16.0	17.8	26.6	16.0	24.0	27.3
	Тэтгэвэрт	27.4	2.7	1.4	1.2	-	-	-	-	-
	Нийт	100.0	99.2	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Өрхийн орлого	100 мянгаас бага	14.5	9.5	10.7	7.5	-	-	-	-	-
	101-200 мянга	22.4	21.6	20.1	16.2	-	-	-	-	-
	201-300 мянга	24.9	26.6	22.9	25.7	-	-	-	-	-
	301-400 мянга	17.9	19.9	17.7	21.8	-	-	-	-	-
	401-500 мянга	11.1	9.8	12.2	13.7	-	-	-	-	-
	500 мянгаас дээш	9.2	9.9	16.4	15.1	-	-	-	-	-
	Нийт	100.0	93.7	100.0	100.0	-	-	-	-	-
	Өрхийн орлого*	200,000 төгрөгөөс доош	-	-	-	-	22.2	25.9	20.7	17.8
200,001-400,000 төгрөг		-	-	-	-	28.5	33.8	30.0	28.5	34.3
400,001-600,000 төгрөг		-	-	-	-	25.1	23.2	26.3	27.5	26.1
600,001-800,000 төгрөг		-	-	-	-	13.7	9.3	14.6	14.9	12.4
800,001-1,000,000 төгрөг		-	-	-	-	5.8	4.7	3.7	6.4	7.6
1,000,000 төгрөгөөс дээш		-	-	-	-	4.7	3.1	4.8	5.0	6.8
Нийт		-	-	-	-	100.0	100.0	100.0	100.0	100.0

Хавсралт 2. Чиглэлийн индексийн тайлбар¹

Түүвэр судалгааны хариултыг шинжлэхдээ чиглэлийн индекс буюу тэнцлийн статистикийг өргөн ашигладаг. Иргэдийн мэдэрсэн болон хүлээгдэж байгаа инфляцийн хандлагыг тооцох энгийн аргыг анх Anderson (1952 он) боловсруулсан байдаг. Тэрээр үнэ өснө гэж хүлээж байгаа нийт хүмүүсийн хувиас үнэ буурна гэж хүлээж байгаа хүмүүсийн хувийг хасч тэнцлийн статистикийг тооцсон (*иргэдийн мэдэрсэн инфляцийг адил аргачлалаар тооцсон*). Олон сонголттой асуулгатай инфляцийн хүлээлтийн түүвэр судалгааны энгийн чиглэлийн индексийг томъёолбол:

$$BS_1^e = A_1^e + A_2^e + A_3^e - C^e, BS_1^p = A_1^p + A_2^p + A_3^p - C^p \quad (1)$$

Үүнд A_1^e гэдэг нь үнийн түвшин илүү хурдацтай өснө, A_2^e -нь үнэ ижил түвшинтэйгээр өснө, A_3^e -нь үнэ маш удаанаар өснө гэж **хүлээж** байгаа хэрэглэгчдийн хариултын хувь юм. Харин C^e - гэдэг нь үнэ буурна гэж хүлээж байгаа иргэдийн хариултын хувь болно. A_1^p -нь 12 сарын өмнөхтэй харьцуулахад өнөөдөр үнэ маш хурдацтай өссөн, A_2^p -нь 12 сарын өмнөхөөс нилээд өндрөөр өссөн, A_3^p -нь 12 сарын өмнөхөөс бага зэрэг өссөн гэж хариулсан буюу хэрэглэгчдийн **мэдэрсэн** инфляцийн хариултын хувь юм. C^p -нь эсрэгээр өнгөрсөн 12 сарын хугацаанд үнийн түвшин буурсан гэж үзэж байгаа иргэдийн хариултын хувь болно.

Anderson (1952)-ий чиглэлийн индексийг бага зэрэг өөрчилсөн хувилбар нь үнэ өснө гэсэн нийт хүлээлтийн хувиас үнийн түвшин тогтмол болон буурна гэсэн хувийг хасч тооцдог:

$$BS_2^e = A_1^e + A_2^e + A_3^e - B^e - C^e, BS_2^p = A_1^p + A_2^p + A_3^p - B^p - C^p \quad (2)$$

Үүнд B^e , B^p -нь харгалзан үнэ буурна гэж хүлээж байгаа болон үнэ 12 сарын өмнөхөөс буурсан гэж мэдэрсэн иргэдийн хариултын хувь юм.

Түүнчлэн Дэл Жиовони (Del Giovane), Саббатанини (Sabbatini) нар 2004 онд хүлээж буй болон мэдэрсэн үнийн өөрчлөлтийг тооцох ялгаатай хэмжигдэхүүнтэй тэнцлийн статистикийг санал болгосон. Олон сонголтод түүвэр судалгааны асуулгын асуулт нэг бүрийн хувьд харгалзах хувийн жин нь ялгаатай байдаг. Энэхүү чиглэлийн индексийн

¹ С.Билгүүн, 2011. “Инфляцийн хүлээлтийг тооцоолох арга, аргачлалыг боловсронгуй болгох нь: Монголын жишээ”.

хариулт бүрд харгалзан $1, \frac{1}{2}, 0, -\frac{1}{2}, -1$ гэсэн хувийн жинг өгөх бөгөөд энэ нь $[-1; 1]$ тоон завсраас утгаа авна.

$$BS_3^e = A_1^e + \frac{1}{2}A_2^e - \frac{1}{2}B^e - C^e, BS_3^p = A_1^p + \frac{1}{2}A_2^p - \frac{1}{2}B^p - C^p \quad (3)$$

Сүүлийн жилүүдэд Европын Төв банк Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаандаа тэгшитгэл (3) хэлбэрээр өгөгдсөн тэнцлийн статистикийг өргөн ашиглаж байна. Түүнчлэн хувийн жин нь бага зэрэг ялгаатай өөр нэг тэнцлийн статистикийг ашиглаж байгаа бөгөөд харгалзах хувийн жингүүд нь 3, 2, 1, 0 болон -1 гэсэн утгыг авна. Үүнийг тэгшитгэл хэлбэрээр илэрхийлбэл:

$$BS_4^e = 3A_1^e + 2A_2^e + A_3^e - C^e, BS_4^p = 3A_1^p + 2A_2^p + A_3^p - C^p \quad (4)$$

Тэнцлийн статистик нь түүвэр судалгаанд тусгагдсан санаа бодлыг нэгдсэн нэг утгаар илэрхийлсэн тоон мэдээллийг өгч, иргэдийн өнгөрсөнд мэдэрсэн болон ирээдүйд хүлээж буй үнийн өсөлтийн **хандлагыг** харуулж чаддаг давуу талтай боловч эдгээр статистик нь инфляцийн хүлээлт болон мэдрэмжийн утгыг яг ойролцоолон тооцоолох боломжгүй байдаг. Өөрөөр хэлбэл, дан ганц чиглэлийн индексийн тусламжтайгаар инфляцийн хүлээлтийг нэг утгатайгаар, нарийн тодорхойлох боломжгүй байдаг.

Хавсралт 3. Инфляцийн хүлээлтийг тооцох магадлалын арга²

Магадлалын аргыг анх Theil (1952) боловсруулсан бөгөөд Carlson ба Parkin (1975), Taylor (1988), Seitz (1988) нар өөрсдийн судалгаандаа өргөтгөн ашигласан байдаг. Инфляцийн хүлээлтийг тооцох хувьсагчид нь үнийн түвшин “*өснө*”, “*өөрчлөгдөхгүй*” эсвэл “*буурна*” гэсэн чанарын хүлээгдэж буй хариултаар илэрхийлэгдэнэ. Чанарын хариулт нь тоон утгаар илэрхийлэгдэхгүй бөгөөд үнийн өөрчлөлтийн ерөнхий хандлагыг харуулдаг. Чанарын хариултыг магадлалын функц ашиглан инфляцийн тоон утганд хөрвүүлж хүлээлтийг тооцон гаргадаг.

Энэ арга нь үндсэн 2 таамаглал дээр тулгуурладаг. Нэгдүгээрт, хувь хүн бүр хүлээгдэж буй үнийн өөрчлөлтийн тархалтын функцтэй байх бөгөөд уг функц нь цаг хугацаа болон хэрэглэгчдийн хувьд ялгаатай байж болно. Хоёрдугаарт, хэрэглэгчдийн хүлээгдэж буй үнийн түвшин нь өөрчлөгдөхгүй гэж үзвэл хүлээгдэж буй үнийн өөрчлөлт нь тэг төвтэй тодорхой интервалын хооронд оршино гэж таамагладаг. Энэ интервалыг “мэдрэмжийн интервал” буюу “өөрчлөлтгүй интервал” гэнэ.

Уг магадлалын аргыг Carlson ба Parkin (1975) нар өөрсдийн ажилдаа өргөтгөн хэрэглэхдээ, хариултын хувилбаруудыг нэмсэн бөгөөд түүврийн тоо хангалттай их бол хүлээгдэж буй үнийн түвшний өөрчлөлт нь нийт хүн амын хувьд хэвийн тархалттай байна гэсэн таамаглалыг тавьсан. Судалгаанд оролцогчид ирэх 12 сар үнийн түвшинг одоогийн түвшинтэй харьцуулахад “*илүү хурдан өснө*”, “*ижил хувиар өснө*”, “*илүү удаан өснө*”, “*хэвэндээ байна*”, “*буурна*”, “*мэдэхгүй*” гэсэн хувилбаруудаас сонголтоо хийнэ. Үүнд, “*хэвэндээ байна*” эсвэл “*ижил хувиар өснө*” гэсэн хоёр хариулт нь тоогоор илэрхийлэгддэг. Хэрэв “*хэвэндээ байна*” гэж үзвэл ирэх 12 сарын хугацаанд үнэ өөрчлөгдөхгүй буюу үнийн өөрчлөлт тэгтэй тэнцэнэ гэсэн үг юм. Эндээс хүлээгдэж буй инфляцийн түвшин нь тэг төвтэй, (-t;t) мэдрэмжийн интервалын хооронд оршино. Харин “*ижил хувиар өснө*” гэж үзвэл хүлээгдэж буй инфляцийн түвшин нь мэдрэгдсэн инфляцийн түвшин дээр төвтэй, ($\pi_{0-s};\pi_{0+s}$) интервалын хооронд оршино.

Мэдрэгдсэн үнийн өөрчлөлтийн түвшинг ихэнх тохиолдолд түүвэр судалгааг явуулж байх хугацаанд мэдэгдэж буй инфляцийн түвшингээр ойролцоолон тооцох аргыг ашигладаг (Berk, 1997; Lyziak 2003). Инфляцийн хүлээлтийг тооцож буй энэхүү

² С.Билгүүн, 2011. “Инфляцийн хүлээлтийг тооцоолох арга, аргачлалыг боловсронгуй болгох нь: Монголын жишээ”.

аргачлалыг инфляцийн хүлээлтийн объектив хандлага гэдэг бөгөөд санал асуулгад оролцогчид үнийн өөрчлөлтийг албан статистикийн тоотой ижил хэмжээгээр мэдэрдэг гэсэн таамаглалыг тавидаг. Харин мэдрэгдсэн инфляцийн түвшинг иргэдийн санал асуулгаар тодорхойлдог аргачлалыг инфляцийн хүлээлтийг тооцох субъектив хандлага гэж нэрлэдэг бөгөөд уг аргачлалын талаар дараагийн хэсэгт дэлгэрэнгүй авч үзнэ.

Carlson ба Parkon (1975) нарын инфляцийн хүлээлтийг тооцох аргачлалыг алгебрийн тэгшитгэл хэлбэрээр илэрхийлбэл дараах байдалтай байна. Үүнд:

$$a = P(\pi_{+12}^e > \pi_0 + s) = 1 - F_c(\pi_0 + s) \quad (5)$$

$$b = P(\pi_0 - s < \pi_{+12}^e < \pi_0 + s) = F_c(\pi_0 + s) - F_c(\pi_0 - s) \quad (6)$$

$$c = P(t < \pi_{+12}^e < \pi_0 - s) = F_c(\pi_0 + s) - F_c(t) \quad (7)$$

$$d = P(-t < \pi_{+12}^e < t) = F_c(t) - F_c(-t) \quad (8)$$

$$e = P(\pi_{+12}^e < -t) = F_c(-t) \quad (9)$$

Стандартчилгдсан хэвийн тархалтын нягтын функц (10)-ыг ашиглан тэгшитгэл (5)-(8)-ыг дараах байдлаар бичих боломжтой.

$$F_c(k) = Nz\left(\frac{k-m}{\sigma}\right) \quad (10)$$

Энэд Nz гэдэг нь хуримтлагдсан стандарт хэвийн тархалтын функц ба m -нь инфляцийн хүлээлтийн түвшний үл мэдэгдэх дундаж утга бол σ -нь стандар хазайлтын утгыг илэрхийлнэ. Тархалтын функцийн интервалын урт s болон t -нь эндоген хувьсагчид юм. Тэгшитгэлийн тайлбарлагч хувьсагчид a, b, c, d, e (судалгааны асуултанд харгалзах хариултуудыг сонгосон хүмүүсийн эзлэх хувь) болон π_0 (мэдрэгдсэн инфляцийн түвшин) болно. Тэгшитгэл (5)-(9)-ын шийд нь дараах байдлаар тодорхойлогдоно:

$$m = \frac{\pi_0 \cdot (C+D)}{C+D-(A+B)} \quad (11)$$

$$\sigma = \frac{-2 \cdot \pi_0}{C+D-(A+B)} \quad (12)$$

$$s = \frac{\pi_0 \cdot (B-A)}{C+D-(A+B)} \quad (13)$$

$$t = \frac{\pi_0 \cdot (D-C)}{C+D-(A+B)} \quad (14)$$

Үүнд: $A = Nz^{-1}(1 - a)$; $B = Nz^{-1}(1 - a - b)$; $G = Nz^{-1}(1 - a - b - c)$; $D = Nz^{-1}(e)$

Тэгшитгэл (11)-ээс харахад хүлээгдэж буй инфляцийн түвшин нь иргэдийн таргалтын функцын хэлбэр болон өнөөдрийн үнийн динамикуыг тэд хэр мэдэрсэнээс хамаарна.